

АРЬС СУДЛАЛ

1. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ НИЙТЛЭГ ШАЛГУУР

- 1.1. Арьс, гоо заслын мэргэжилтэнд **ахлах** зэрэг олгоход дараах **нийтлэг шалгуурыг** баримтална. Үүнд:
 - 1.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх
 - 1.1.2. Мэргэжлээрээ 8- ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх. /нийгэм даатгалын дэвтрийн хуулбар/
 - 1.1.3. Тухайн мэргэжлээр төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх
 - 1.1.4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх /харъяалагдах ёсзүйн салбар хорооны тодорхойлолт/
- 1.2. Арьс, гоо заслын мэргэжилтэнд **тэргүүлэх** зэрэг олгоход дараах **нийтлэг шалгуурыг** баримтална. Үүнд:
 - 1.2.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх
 - 1.2.2. Тухайн мэргэжлээрээ ахлах авснаас хойш 5 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан байх /нийгэм даатгалын дэвтрийн хуулбар/
 - 1.2.3. Магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх**
 - 1.2.4. Ёс зүйн болон мэргэжлийн алдаа гаргаагүй байх /харъяалагдах ёсзүйн салбар хорооны тодорхойлолт/
- 1.3. Арьс, гоо заслын мэргэжилтэнд **зөвлөх** зэрэг олгоход дараахи нийтлэг **шалгуурыг** баримтална. Үүнд:
 - 1.3.1. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхтэй байх
 - 1.3.2. Мэргэжлээрээ 20 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан одоо тухайн мэргэжлээрээ ажиллаж буй /нийгэм даатгалын дэвтрийн хуулбар/
 - 1.3.3. Тухайн мэргэжлээрээ төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх
 - 1.3.4. Боловсролын докторын зэрэгтэй байх**

2. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ТУСГАЙ ШАЛГУУР

- 2.1. Арьс, гоо заслын мэргэжилтэнд **ахлах** зэрэг олгоход дараахи **тусгай шалгуурыг** баримтална. Үүнд:
 - 2.1.1. Мэргэжил дээшлүүлэх сургалтаар 15 кр биелүүлсэн байх
 - 2.1.2. Ур чадвар: эмчилгээ оношлогоо үйлчилгээнд шинэ бүтээл нэвтрүүлсэн байх /тухайн байгууллагын тодорхойлолт, патент зохиогчийн эрхийн гэрчилгээ/
 - 2.1.3. Судалгаа шинжилгээний ажил:
 - 2.1.3.1. Илтгэл, өгүүлэл мэргэжлийн хурал зөвлөгөөн, сэтгүүлд – 5

- 2.2. Арьс, гоо заслын мэргэжилтэнд **тэргүүлэх** зэрэг олгоход дараах **тусгай шалгуурыг** баримтална. Үүнд:
 - 2.2.1. Мэргэжил дээшлүүлэх сургалтаар ахлах зэрэг авснаас хойш 8 кр биелүүлсэн байх
 - 2.2.2. Судалгаа шинжилгээний ажил:
 - 2.2.2.1. Илтгэл, өгүүлэл /дотоод – 5, гадаадад хурал, сэтгүүлд – 1/
 - 2.2.3. Ёс зүйн доголдол гаргаагүй байх / харъяалагдах ёсзүйн салбар хорооны тодорхойлолт/
 - 2.2.4. Ур чадвар: эмчилгээ оношлогоо үйлчилгээнд шинэ бүтээл нэвтрүүлсэн байх /тухайн байгууллагын тодорхойлолт, патент зохиогчийн эрхийн гэрчилгээ/
 - 2.2.5. Мэргэжлийн сургалтуудыг удирдсан байх
- 2.3. Арьс, гоо заслын мэргэжилтэнд **зөвлөх** зэрэг олгоход дараахи **тусгай шалгуурыг** баримтална. Үүнд:
 - 2.3.1. Магистр, докторант удирдах, дипломын ажилд шүүмж өгсөн байх**
 - 2.3.2. Судалгаа шинжилгээний ажил:
 - а. Ном товхимол бичсэн байх
 - б. Илтгэл өгүүлэл гадаадад – 3
 - 2.3.3. Ёс зүйн доголдол гаргаагүй байх /харъяалагдах ёс зүйн салбар хорооны тодорхойлолт/
 - 2.3.4. Ур чадвар: эмчилгээ оношлогоо үйлчилгээнд шинэ бүтээл нэвтрүүлсэн байх /тухайн байгууллагын тодорхойлолт, патент зохиогчийн эрхийн гэрчилгээ/

3. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ МЭРГЭЖИЛТНИЙ БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

- 3.1. Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн хувийн өргөдөл
- 3.2. Мэргэжлийн зэрэг горилогчийн анкетыг бүрэн бөглөж байгууллагын даргаар баталгаажуулсан маягт (Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталгаажуулсан загвараар)
- 3.3. МАӨЭННийгэмлэгийн мэргэжлийн зэргийн шалгалтын журмын нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлт хангасныг баталгаажуулах баримтууд
- 3.4. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу зөвшөөрөл шаардлагагүй мэргэжилтэнд мэргэжил эзэмшсэн диплом, мэргэжлийн үнэмлэхний баталгаажсан хуулбар
- 3.5. Мэргэжлийн зэрэг өмнө нь хамгаалсан бол үнэмлэхний эх хувь
- 3.6. Нотариатаар баталгаажсан иргэний үнэмлэхний хувь
- 3.7. 3x4 хэмжээний зураг 2%